



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 596

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант суманд барьж ашиглалтад оруулсан 960 оюутны хичээлийн байрны өргөтгөлийн ажлын хүрээнд бий болсон нийт 5,181,274,602.00 (таван тэрбум нэг зуун наян нэгэн сая хоёр зуун далан дөрвөн мянга зургаан зуун хоёр) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Ховд аймаг дахь Хөгжил Политехник коллежийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Ховд аймаг дахь Хөгжил Политехник коллежийн захирал Д.Баярмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 8 дугаар сарын 29 ны өдрийн
526 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМАГ ДАХЬ ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Бүртгэлд тусгах дүн	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт	Гүйцэтгэгч байгууллага
			(төгрөг)	(дугаар)	(хуулийн этгээдийн нэр)
1	Хөгжил политехник коллежийн барилга/ Ховд, Жаргалант сум)	2021.10.08	5,181,274,602.00	ББКД/55/2021	Мотоблок ХХК, Ховдын Өргөө ХХК түншлэл
НИЙТ ДҮН			5,181,274,602.00 (таван тэрбум нэг зуун наян нэгэн сая хоёр зуун далан дөрвөн мянга зургаан зуун хоёр)	-	-